



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/117

Хэрлэн сум

Модны суулгац худалдан авахад
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Арвантавдугаар хуралдааны 06 дугаартай “Аймгийн 2023 оны Төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинээр хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд шаардагдах модны суулгац худалдан авахад 35,900,000 (гучин таван сая есөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг 2023 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 03-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮	Худалдан авсан байгууллага
1	"Цэнгэлдэх хүрээлэнгийн шинэ цэцэрлэгт хүрээлэн"-д шар хуайс модны суулгац худалдан авах	ш	3600	4,500	16,200,000	Грийн пайн ХХК
2	"Цэнгэлдэх хүрээлэнгийн шинэ цэцэрлэгт хүрээлэн"-д шар хуайс модны суулгац худалдан авах	ш	700	4,500	3,150,000	Грийн Фантом ХХК
3	"Цэнгэлдэх хүрээлэнгийн шинэ цэцэрлэгт хүрээлэн"-д шар хуайс модны суулгац худалдан авах	ш	300	4,000	1,200,000	Хэнтий шинэс СДОА/
4	Үерийн далангийн дагуу хамгаалатын зурвас байгуулахад улиас модны суулгац худалдан авах	ш	2275	2,000	4,550,000	Хурхнаг жибуур ХХК
5	"Их Хуралдай Орд Өргөө цогцолбор"-т нарс модны суулгац худалдан авах, тариулах	ш	180	60,000	10,800,000	2022 оны авсан модны төлбөр Биндэр ой СДОА
					35,900,000	